



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/214

Булган сум

Эзэмшил газрын зориулалт өөрчлөх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар баталсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам", аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн хуралдааны IX/19 дүгээр тогтоолоор баталсан "Булган сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-г тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Иргэн С.Мөнхболор (ФБ91032961)-ын Булган сум 5 дугаар баг Л.Энэбиш 2 дугаар гудамж 245 тоотод байршилтай 6308003601 нэгж талбар бүхий худалдаа, үйлчилгээний зориулалтаар эзэмшиж буй 1596 м2 газрын зориулалтыг үйлчилгээтэй орон сууц, П.Сүхбаатар (ГЭ76021613)-ын Булган сум 5 дугаар баг Л.Энэбиш 2 дугаар гудамж 243 тоотод байршилтай 6308003671 нэгж талбар бүхий худалдаа, үйлчилгээний зориулалтаар эзэмшиж буй 1179 м2 газрын зориулалтыг үйлчилгээтэй орон сууц, Т.Одгэрэл (ГЭ77071102)-ийн Булган сум 5 дугаар баг Хатанбаатар С.Магсаржав 4 дүгээр гудамж 403 тоотод байршилтай 6308009697 нэгж талбар бүхий худалдаа, үйлчилгээний зориулалтаар эзэмшиж буй 1420 м2 газрын зориулалтыг автомашины гарааш болгон тус тус өөрчилсүгэй.

2. С.Мөнхболор, П.Сүхбаатар, Т.Одгэрэл нартай газар эзэмшүүлэх гэрээг шинэчлэн байгуулж, гэрчилгээжүүлэн газар эзэмшилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2016 оны А/373 дугаар захирамжийн С.Мөнхболор, 2021 оны А/345 дугаар захирамжийн П.Сүхбаатар, 2024 оны А/57 дугаар захирамжийн Т.Одгэрэл нартай холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Sugar Ажил 2024 өдөр бүр Doc/2024/Захирамж

6324010291